



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН НЭР: СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/06-ШТА-НА

УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙГ ХОЛБОГДОХ ЖУРМЫН ДАГУУ
ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

Цахим хуудас
www.audit.mn

ДАЛАНЗАДГАД ХОТ
2024 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Т.Өсөхбаяр
Утас: 70533552
Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn
Аудитын менежер: Т.Хонгорзул
Утас: 70533552
Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn
Аудитор: О.Чойдорж
Утас: 70533552
Цахим хаяг: ChoidorjO@audit.gov.mn
Аудитор: Э.Жамцдорж
Утас: 70533552
Цахим хаяг: JamtsdorjE@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Ерөнхий мэдээлэл	5
Бүлэг 1. Улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.....	6
Бүлэг 2. Улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.....	8
Дүгнэлт.....	13
Холбогдох байгууллагын санал.....	14
Тайлан баталгаажуулах тушаал.....	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо

ХҮСНЭГТИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	АСХ-ы батлагдсан төсөв зардлын ангилал	5
2	АСХ-оос сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв	6
3	Өмнөговь аймгийн УБХ-ийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл	7
4	Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын батлагдсан төсөв, гүйцэтгэл	7
5	АСХ, сумдын сонгуулийн хорооны төсвийн хэмнэлт	8
6	Аймаг, сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл зардлын ангилал	9
7	Аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл	10
8	Аудитаар илэрсэн алдааг залруулсан байдал	10
9	Аудитаар илэрсэн зөрчил	12

ДҮРСЛЭЛИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг Өмнөговь аймгийн хэмжээнд зохион байгуулахтай холбоотой батлагдсан нийт төсвийн ангилал	5

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэл”-д аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аудитын тайланг Үндэсний аудитын газар, бусад байгууллага, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Энэхүү зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын Их Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журмын дагуу төлөвлөж, хуваарилсан эсэх;
- Улсын Их хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг зориулалтын дагуу арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн сонгуулийн хороо, сумын сонгуулийн хороод, Цагдаагийн газар, Улсын бүртгэлийн хэлтэс болон холбогдох бусад байгууллагуудыг хамрууллаа.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБООС 100, 400, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, Нийцлийн аудит MNS 6817:2020, Нийцлийн болон Санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Т.Хонгорзул хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Шижирболд, аудитор О.Чойдорж, Э.Жамцдорж нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн, тайланг 2024 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн дотор үе шатны хяналтаар оруулж, баталгаажуулан, 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Үндэсний аудитын газар болон аймаг, сумдын сонгуулийн хороонд хүргүүлэв.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар 78 гишүүнийг олныг төлөөлөх /мажоритар/ аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх /пропорциональ/ аргаар сонгож 126 гишүүнтэй байхаар 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар өөрчлөн найруулсан байна.


УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар Өмнөговь аймгийн хэмжээнд сонгуулийн насны иргэдийн тоо 48,080 бүртгэлтэй байснаас 31,740 иргэн буюу 66.0 хувь саналаа өгсөн байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн “Аймаг, нийслэлийн сонгуулийн зардлын төсөв батлах тухай” А/45 дугаар тушаалын хавсралтаар УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн Өмнөговь аймгийн сонгуулийн хорооны төсвийг 671,569.0 мянган төгрөг, аймгийн сонгуулийн хороо 1, сумын сонгуулийн хороо 15, хэсгийн тоо 63 байхаар тус тус баталсан байна.

Өмнөговь аймгийн сонгуулийн хороо нь батлагдсан төсвөөс 659,569.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж, 11,999.5 мянган төгрөгийг СЕХ-ы дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн “Монгол Улсын Их хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардлын төсвийг батлах тухай” А/24 дүгээр тушаалаар 60,688.3 мянган төгрөгийн төсөв, 2024 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн “Зардал гаргах тухай” А/104 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардалд 4,040.0 мянган төгрөгийн төсөв нийт 64,728.3 мянган төгрөгийн төсөв, мөн ЦЕГ-аас УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсвийг Өмнөговь аймгийн Цагдаагийн газарт 37,286.0 мянган төгрөгөөр тооцож тус тус хуваарилсан байна.

Дүрслэл 1. УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг Өмнөговь аймгийн хэмжээнд зохион байгуулахтай холбоотой батлагдсан нийт төсвийн ангилал



■ Цагдаагийн газар ■ Улсын бүртгэлийн хэлтэс ■ Сонгуулийн хороо ■

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ХӨРӨНГИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ТӨЛӨВЛӨЖ, ХУВААРИЛСАН БАЙНА.

1.1. Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын даргын 2024 оны А/45 дугаартай тушаалаар УИХ-ын 2024 оны сонгуулийн Өмнөговь АСХ-ны төсвийг 671,569.0 мянган төгрөгөөр төсөвлөж баталсан байна.

Хүснэгт 1. АСХ-ы батлагдсан төсөв зардлын ангиллаар.

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв (мянган төгрөг)
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0
2	Сонгуулийн хорооны сургалтын зардал	9,140.0
3	МТБ, Даамлын сургалт	14,920.0
4	Бичиг хэрэг	10,810.0
5	Шуудан холбоо	12,700.0
6	Унааны зардал	53,900.0
7	Санал авах байрны зардал	19,530.0
8	Сурталчилгаа	8,000.0
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийн СЕХ-оос авах, буцаан хүлээлгэн өгөх	39,256.0
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах холбоо унааны	1,300.0
11	Сонгуулийн дүн баримт бичгийг хүлээлгэн өгөх унаа томилолтын зардал	10,685.0
12	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны урамшуулал	449,510.0
13	Хоолны зардал	33,340.0
14	Шуурхай багын зардал	2,130.0
15	Болзошгүй зардал	6,048.0
Дүн		671,569.0

Эх сурвалж: АСХ-ы УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн нэгтгэл

Монгол Улсын СЕХ-ны 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдийн А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-д заасны дагуу төсвийг АСХ-нд хуваарилсан байна.

Мөн АСХ-нд СЕХ-ны Тамгын газрын даргын 2024 оны 3/229, 3/290, 3/373, 3/472, 3/562 тоот албан бичгүүдээр санхүүжилтийн хуваарийн тайлбар, сумын сонгуулийн хороодод зардлыг хэрхэн хуваарилах талаар тодорхой тусгаж өгсөн байлаа.

1.2. Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Өмнөговь аймгийн хэмжээнд 15 сумын сонгуулийн хороо, 63 хэсгийн хороо байгуулагдан ажилласан байна. АСХ-ы даргын 2024 оны А/02 дугаар захирамжаар 92,830.0 мянган төгрөг, А/03 дугаар захирамжаар 22,880.0 мянган төгрөг, А/04 дүгээр захирамжаар 493,460.0 мянган төгрөг нийт 609,170.0 мянган төгрөгийг 15 сумын сонгуулийн хороонд Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”,-ын дагуу тооцож хуваарилсан байна.

Хүснэгт 2. АСХ-оос сумын сонгуулийн хороодод хуваарилсан төсөв.

(мянган төгрөг)

№	Сонгуулийн хорооны нэр	А/02 дугаар захирамжаар хуваарилсан төсөв	А/03 дугаар захирамжаар хуваарилсан төсөв	А/04 дүгээр захирамжаар хуваарилсан төсөв	Нийт дүн
1	Баян-Овоо сум	5,873.0	1,522.0	25,250.2	32,645.2
2	Булган сум	5,442.0	1,674.4	26,588.4	33,704.8
3	Баяндалай сум	4,839.0	1,312.0	25,145.2	31,296.2
4	Гурвантэс сум	8,586.0	2,466.0	40,319.2	51,371.2
5	Мандал-Овоо сум	5,589.0	1,340.0	25,159.2	32,088.2
6	Манлай сум	6,517.0	2,044.0	32,101.2	40,662.2
7	Номгон сум	8,155.0	2,036.8	40,019.6	50,211.4
8	Ноён сум	4,643.0	1,324.8	18,561.6	24,529.4
9	Сэврэй сум	6,623.0	1,664.8	25,321.6	33,609.4
10	Ханбогд сум	8,297.0	2,440.0	32,229.2	42,966.2
11	Ханхонгор сум	4,725.0	1,470.0	31,814.2	38,009.2
12	Хүрмэн сум	4,237.0	712.4	25,100.4	30,049.8
13	Цогт-Овоо сум	5,025.0	1,412.8	25,195.6	31,633.4
14	Цогтцэций сум	6,519.0	1,340.0	33,917.2	41,776.2
15	Даланзадгад сум	7,760.0	120.0	86,737.2	94,617.2
Дүн		92,830.0	22,880.0	493,460.0	609,170.0

Эх сурвалж: Өмнөговь АСХ-ны даргын 2024 оны А/02, А/03, А/04 дүгээр захирамж

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-с ирүүлсэн аймаг нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбарт заасан газар нутгийн байршил, сумын сонгуулийн хороо, хэсгийн хороодын тоо, түүнд ажиллах хүний тоо зэрэг тодорхой мэдээллүүд дээр тулгуурлан тооцож төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна..

1.3. Сонгууль зохион байгуулахтай холбоотой зарим төрийн захиргааны байгууллагууд төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2¹, 10.3² дахь хэсэгт тус тус заасны дагуу УБЕГ, ЦЕГ нь УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбогдон гарах зардлын төсвийг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна

УБЕГ-ын даргын 2024 оны А/24 дүгээр тушаалаар УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны хүрээнд 60,688.3 мянган төгрөг, А/104 дүгээр тушаалаар сонгуулийн санал авах байруудыг улсын бүртгэлийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох “Тоног төхөөрөмжийн туршилтыг орон нутагт хийхэд шаардагдах зардал”-д 4,040.0 мянган төгрөгөөр тус тус төсөвлөн хуваарилсан байна.

¹ Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

² Сонгууль зохион байгуулахтай холбогдсон дараах зардлыг цагдаагийн байгууллагын тухайн жилийн төсөвт тусган батлуулж, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Хүснэгт 3. Өмнөговь аймгийн УБХ-ийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл

(мянган төгрөг)

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл
1	Итгэмжлэгдсэн ажилтны урамшуулал	39,982.5	39,982.5
2	Сонгуулийн нэрсийн жагсаалт хэвлэхэд шаардагдах төсөв	2,775.8	2,789.8
3	Сонгуулийн нэрсийн жагсаалт хүргэх	1,912.0	1,912.0
4	Сургалтын томилолт унааны зардал	8,832.0	8,832.0
5	Сургалтын бусад зардал	1,300.0	1,300.0
6	Тоног төхөөрөмж хүргэж авах албан томилолт	1,136.0	1,136.0
7	Тоног төхөөрөмж хүргэж авах тээврийн зардал	4,400.0	4,400.0
8	Шуурхай багийн зардал	350.0	336.0
Дүн		60,688.3	60,688.3
1	Тоног төхөөрөмж турших зардлын хүрээнд	4,040.0	4,040.0
Нийт дүн		64,728.3	64,728.3

Эх сурвалж: УБХ-ын зардлын тайлан

Аймгийн УБХ нь албан томилолтын төсөв, гүйцэтгэлийг тооцож олгохдоо Монгол Улсын Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалд заасан тарифаар тооцож байна.

Мөн ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт УИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн хамгаалалтын зардлын төсвийг хэсгийн хороодын тоо, хамгаалалтад үүрэг гүйцэтгэх алба хаагчдын тоо зэрэгт үндэслэн 37,286.0 мянган төгрөгөөр тооцож хуваарилсан байна.

Хүснэгт 4. Өмнөговь аймгийн Цагдаагийн газрын батлагдсан төсөв, гүйцэтгэл

(мянган төгрөг)

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт
1	Түлш, шатахуун	2,000.0	2,000.0	-
2	Хоолны зардал	10,350.0	10,350.0	-
3	Шуудан холбооны зардал	24,936.0	24,936.0	-
Дүн		37,286.0	37,286.0	-

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Цагдаагийн газар, УБХ нь 2024 оны ээлжит сонгуулийн зардлын төсвийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, төсвийн төвлөрүүлэн захирагчдаас ирүүлсэн зардлын төсөвт заасан зориулалтын дагуу эрх нээлгэсэн байна.

БҮЛЭГ 2. УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛААГҮЙ БАЙНА.

2.1 Батлагдсан төсвөөс 900.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Аудитаар АСХ, сумдын сонгуулийн хорооны төсвийн гүйцэтгэлийг тайланг анхан шатны баримт, төрийн сангийн дансны хуулгатай тулган батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахад Баян-овоо, Булган, Мандал-овоо, Ханбогд зэрэг сумдын сонгуулийн хороо нь 900.5 мянган төгрөгийг зохих эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна.

Хүснэгт 7. Аудитаар илэрсэн зөрчлийн бүртгэл

№	Сонгуулийн хорооны нэр	Мөнгөн дүн (мянган төгрөг)	Аудитаар илэрсэн зөрчлийн товч утга
1	Баян-Овоо сум	80.0	Бичиг хэргийн зардлаас хэвлэл хийлгэсэн.
2	Булган сум	153.0	Бичиг хэргийн зардлаас хэвлэл хийлгэсэн.
3	Мандал-Овоо сум	45.5	Санал авах байрны зардлаас бичиг хэргийн материал бэлтгэсэн.
4	Ханбогд сум	247.0	Санал авах байрны зардлаас шатахуун худалдан авсан
		375.0	Шуудан холбооны зардлаас бараа материал бэлтгэсэн.
Нийт дүн		900.5	

Эх сурвалж: Аудитын тайлангаар

Дээрх зөрчилд төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³, Монгол Улсын сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.2⁴, 3.6⁵ дахь хэсэгт заасныг тус тус мөрдөж ажиллах албан шаардлагыг зөрчил гаргасан сумын сонгуулийн хорооны дарга нарт хүргүүлсэн.

Өмнөговь АСХ-нд 671,569.0 мянган төгрөгийн зардлын санхүүжилт хуваарилагдсанаас 659,569.5 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулж, 11,999.5 мянган төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт 5. АСХ, сумдын сонгуулийн хорооны төсвийн хэмнэлт

(мянган төгрөг)

№	Сонгуулийн хорооны нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэлт
1	Баяндалай сум	31,296.2	30,553.0	2,663.2
2	Баян-овоо сум	32,645.2	32,645.2	1,609.2
3	Булган сум	33,704.8	33,301.0	897.4
4	Гурвантэс сум	51,371.2	48,708.0	743.2
5	Даланзадгад сум	94,617.2	94,214.0	545.2
6	Мандал-овоо сум	32,088.2	31,190.8	403.8
7	Манлай сум	40,662.2	40,259.0	403.4
8	Ноён сум	24,529.4	23,984.2	403.2
9	Номгон сум	50,211.4	49,808.0	403.2
10	Сэврэй сум	33,609.4	33,609.4	253.8
11	Ханбогд сум	42,966.2	42,818.0	148.2
12	Ханхонгор сум	38,009.2	38,006.0	3.2
13	Хүрмэн сум	30,049.8	29,796.0	-
14	Цогт-овоо сум	31,633.4	31,633.4	-
15	Цогт-цэций сум	41,776.2	40,167.0	-
16	АСХ	62,399.0	58,876.5	3,522.5
Нийт дүн		671,569.0	659,569.5	11,999.5

³ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁴ "Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1-р гарын үсгийг, Сонгуулийн хорооны даргын захирамжаар томилогдсон нягтлан бодогч нь 2-р гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна"

⁵ Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулна.

Эх сурвалж: Аудитын судалгаа.

Дээрх хүснэгтээс харахад Баян-Овоо, Сэврэй, Цогт-Овоо сумын сонгуулийн хороод батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан бол бусад сумын сонгуулийн хороод нийт 11,999.5 мянган төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Хүснэгт 6. Аймаг, сумдын сонгуулийн хорооны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл зардлын ангиллаар.

(мянган төгрөг)

№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Төсвийн гүйцэтгэл	Хэмнэлт
1	Маягт хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардал	300.0	268.5	31.5
2	Сонгуулийн хорооны сургалтын зардал	9,140.0	8,724.0	416.0
3	Мэдээлэл технологийн баг, Даамлын сургалт	14,920.0	14,781.0	139.0
4	Бичиг хэрэг	10,810.0	10,552.2	257.8
5	Шуудан холбоо	12,700.0	12,697.1	2.9
6	Унааны зардал	53,900.0	50,012.0	3,888.0
7	Санал авах байрны зардал	19,530.0	19,446.7	83.3
8	Сурталчилгаа	8,000.0	8,000.0	-
9	Саналын хуудас, санал тоолох төхөөрөмжийн СЕХ-оос авах, буцаан хүлээлгэн өгөх	39,256.0	36,730.0	2,526.0
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал	1,300.0	1,300.0	-
11	Сонгуулийн хороонд ажилласан хугацааны урамшуулал	449,510.0	448,894.0	616.0
12	Хоолны зардал	33,340.0	33,290.0	50.0
13	Сонгуулийн дүн баримт бичгийг хүлээлгэн өгөх унаа томилолтын зардал	10,685.0	10,360.0	325.0
14	Шуурхай багын зардал	2,130.0	2,130.0	-
15	Болзошгүй зардал	6,048.0	2,384.0	3,664.0
	Дүн	671,569.0	659,569.5	11,999.5

Эх сурвалж: Аудитын судалгаа

АСХ болон сумдын сонгуулийн хороо нь сурталчилгааны зардал, мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах холбоо, унааны зардал, шуурхай багын зардлыг бүрэн зарцуулсан бол бусад зардлыг нийт 11,999.5 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

2.2. Зардлын тайланг 120.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

АСХ нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар баталсан аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлангийн маягтаар, сумын сонгуулийн хороод нь тус захирамжийн 3 дугаар хавсралтаар баталсан сум, дүүргийн сонгуулийн хорооны зардлын тайлангийн маягтаар зардлын тайлангаа бэлтгэсэн байна.

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайланг зардлын гүйцэтгэлээр тулган баталгаажуулахад 120.3 мянган төгрөгийн төсвийн гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан байна.

Хүснэгт 8. Аудитын тулган баталгаажуулалт

(мянган төгрөг)

№	Сонгуулийн хорооны нэр	Зардлын нэр	Тайлангаар	Аудитаар	Зөрүү
1	Баяндалай	Бичиг хэргийн зардал	372.8	253.3	119.5
2	Номгон	Унааны зардал	4,490.0	4,489.8	0.2
3	Хүрмэн	Унааны зардал	1,800.0	1,799.4	0.6
Дүн			6,662.8	6,542.5	120.3

Эх сурвалж: Сонгуулийн хорооны зардлын тайлан

Дээрх зардлын гүйцэтгэлийг зөрүүтэй тайлагнасан 120.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан.

2.3. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

АСХ-ны нягтлан бодогч нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 3.3.1⁶, 3.3.2⁷-т заасан шаардлагыг хангасан байна.

НДЕГ-ын 2024 оны 05 сарын 29-ны өдрийн 04/1116 тоот албан бичигт “*аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын Тамгын газар бүх шатны сонгуулийн хэсэг хороонд ажиллахаар томилогдсон иргэнийг тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, эрүүл мэндийн даатгалд даатгуулж, түүнд олгосон урамшууллаас ажил олгогч (12.0 хувь)-ийн болон даатгуулагч (11.3 хувь)-ийн төлөх хувь хэмжээгээр, нийтдээ 23.3 хувиар шимтгэл ногдуулан төлж, даатгуулагчийн төрлийн “76001” кодоор тайлагнана*” гэж заасны дагуу АСХ, сумдын сонгуулийн хороо нь нийгмийн даатгалын шимтгэлийг тооцсон байна.

Хүснэгт 8. Аудитаар илэрсэн зөрчлийг сумдаар

(мянган төгрөг)

№	Сонгуулийн хорооны нэр	Анхан шатны баримтын бүрдэлийг бүрэн хангаагүй баримтаар томилолт олгосон	Жолоочийн тооцооны хуудасгүй шатахуун зарцуулсан	Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм хэтрүүлсэн
1	Баян-овоо сум	-	760.6	444.7
2	Булган сум	-	629.8	425.0
3	Баяндалай сум	208.0	1,267.1	716.8
4	Гурвантэс сум	2,380.0		
5	Мандал-овоо сум	-	1,296.8	39.6
6	Манлай сум	-		1,432.4
7	Номгон сум	-		856.5
8	Ноён сум	-		1,058.9
9	Сэврэй сум	-	1,653.6	1,085.7
10	Ханбогд сум	-		1,701.3
11	Ханхонгор сум	-		512.1
12	Хүрмэн сум	-	2,217.6	936.1
13	Цогт-овоо сум	2,210.0	403.2	513.8
14	Цогт-цэций сум	-		46.4
15	Даланзадгад сум	-		225.30
Нийт дүн		4,798.0	8,228.7	9,994.6

⁶ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын дагуу магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийг нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн мэргэжлээр бакалавр буюу түүнээс дээш зэрэглэлээр төгссөн байх.

⁷ -Төсвийн байгууллагад нягтлан бодогчоор 3-аас доошгүй жил ажилласан, бие даан санхүүгийн тайлан гаргах чадвартай байх.

Аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- УИХ-ын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан гарсан зардлын зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгахад анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаагүй 4,798.0 мянган төгрөгийн томилолт олгосон, жолоочийн тооцооны хуудасгүй 8,228.7 мянган төгрөг, жишиг норм хэтрүүлсэн 9,994.6 төгрөгийн шатахууныг зарцуулсан,

- Ноён сумын сонгуулийн хорооны зардлын дансны 2 дугаар гарын үсэг зурах нягтлан бодогчийг сумын сонгуулийн хорооны даргын захирамжаар томилоогүй хуваарилсан төсвийг захиран зарцуулсан.

Дээрх зөрчлүүдэд зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлагыг сумдын сонгуулийн хороонд хүргүүлээ.

Цаашид сумдын сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогчид анхан шатны баримтын иж бүрэн, үнэн зөв эсэхэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудит хийх явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Улсын төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон байна.
- Сонгуулийн хороодод төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.
- Батлагдсан төсвөөс 900.5 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
- Зардлын тайланг 120.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
- Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт хэрэгжүүлээгүй байна.

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
СОНГУУЛИЙН ХОРОО**

“Товь” танхим, Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: 70532849
Цахим шуудан: Umnugovi.ONS2024@gmail.com

2024.08.15 № 02
танай _____ -ны № _____ -т

**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

Улсын Их Хурлын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтэд өгөх санал тайлбар байхгүй болно.

Аудитаар илэрсэн зөрчлийг сумдын сонгуулийн хороо тус бүрээр дамжуулан алдааг дахин гаргахгүй байхаар анхаарч ажиллах болно.

ДАРГА  Ц.АМАРТӨГС



4624050004

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛАХ ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/128

Даланзадгад сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/102 дугаар "Эрх шилжүүлэх тухай" тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сонгууль зохион байгуулахтай холбогдсон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт гаргах" сэдэвт нийцлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар болон Өмнөговь аймгийн сонгуулийн хороонд тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Шижирболд)-т үүрэг болгосугай

3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулж ажиллахыг аудитор (Э.Жамцдорж)-т даалгасугай.



Ц.ӨСӨХБАЯР

010010084